

Олон Улс Судлал №3, 2014 он: хуудас 69-86.

Монгол Улс, ХБНГУ-ын өнөө үеийн харилцаанд Төв ба Зүүн Азийн хүчин зүйл нөлөөлж байна уу?

Ц.Лхам*

Товч хураангуй: Өнөө үеийн буюу 1990-ээд оноос хойших үеийн Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)-ын харилцааг судлан үзэхэд тус хоёр орны харилцааг ахиулан хөгжүүлэхэд олон хүчин зүйл, бодлого сонирхол дорвитой нөлөөлөл үзүүлсээр иржээ. Үүнээс ялангуяа Төв ба Зүүн Азийн хүчин зүйл нь 1992 оноос хойш Монгол-Германы харилцаанд үндсэн суурь дэвсгэр байдлаар байнгын таатай нөлөө үзүүлж байна.

Энэ нь нэг талаас Төв ба Зүүн хойд Азийн бүс нутагт тогтвортой байдал, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх гэсэн Монгол Улсын идэвхтэй байр суурь, бодит үйлдэл, цаана өөрт нь хадгалагдаж буй ихээхэн боломж, нөгөө талаас энэхүү боломжийг ашиглан Төв ба Зүүн Азид тогтвортой байдал, харилцан ойлголцлыг бэхжүүлэх гэсэн ХБНГУ-ын бодлого харилцан нийцсэнээр 1990-ээд оноос хойшихи Монгол-Германы харилцаанд эерэг нөлөө үзүүлж буй нэгэн хүчин зүйл болж байна.

Abstract: According to my research about relations between Mongolia and Germany after the 1990's, there are many factors, policies and interests that have influenced the two countries relationship development.

*Шинжлэх Ухааны Академийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, докторант

ОЛОН УЛС СУДЛАЛ

In particular, Central and East Asian factors have had positive impacts and have become the basis of the relationship between Germany and Mongolia since 1992.

Mongolia's initiative effort and activities to improve stability and cooperation in Central and Northeast Asia and Germany's policy of strengthening its stable relations and mutual agreements in this area have met and positively influenced the relationship between Mongolia and Germany since the 1990's.

Түлхүүр үгс: Монгол-Германы өнөө үеийн харилцаа, Герман ба Европын Төв Азийн бодлого, Германы Төв ба Зүүн Ази дах ашиг сонирхол

Key words: Current relationship between Mongolia and Germany, Foreign policy of Germany and Europe to Central Asia, Germany's interest in Central and East Asia.

* * *

1. Монгол Улс, ХБНГУ-ын харилцаа 1990-1992



1974 онд ХБНГУ, Бүгд Найрамдах Монгол Ард Улс (БНМАУ)-ын хооронд дипломат харилцаа тогтсоноос хойш 1990 он хүртэл хугацаанд хоёр орны харилцаа нь эрс тэс ялгаатай үзэл суртлын улмаас төдийлөн идэвхтэй хөгжиж чадаагүй байсан ч 1990 онд Германы хоёр улс нэгдэж, Монгол Улс ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих давхар шилжилтийг хийж эхэлснээр хоёр талын харилцаа идэвхжин хөгжих болсон билээ.

Ийнхүү идэвхжин хөгжихөд түлхэц үзүүлсэн гол хүчин зүйлс нь нэг талаас ХБНГУ нь Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улс(БНАГУ)-ыг өвлөн авагч улс болохын хувьд БНАГУ-БНМАУ-ын хуучин хамтын ажиллагааны төвшинг аль болох бууруулахгүй байх бодлогыг¹ баримталж байсан явдал, мөн нөгөө талаас БНМАУ нь гадаад улс төр, геополитикийн цоо шинэ нөхцөл байдалд нийцэн зохицохын зэрэгцээ дотоод эдийн засгийн уналтын байдлаасаа гарахын тулд ХБНГУ-ын

¹ Тухайн үед БНАГУ нь БНМАУ-тай ЗХУ-ын дараа орох хэмжээний сайн харилцаатай байсан. Ц.Лхам. Монгол-Германы харилцааг үечлэх асуудалд (1990 оноос хойш), Герман Судалгаа, мэдээлэл. 2007. Nr.2 (8), 23-25 дугаар тал.

тус дэмжлэгийг бүхий л талаар авах бодлогыг² баримталж байсан явдал зэрэг болно.

2. Монгол Улс, ХБНГУ-ын харилцаа 1992-2005

Энэ үед Монгол Улс ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үйл явцыг тууштай үргэлжлүүлсээр улс төрийн хувьд тогтвортой, ардчилал, хүний эрхийг дээдэлдэг улс болсон нь хоёр орны харилцаа цаашид шинэ агуулгаар баяжин хөгжих таатай хөрсийг бүрдүүлсэн.

Энэ үед нэг талаас, Монгол Улс нь ХБНГУ-ыг “гуравдагч хөрш”-өө болгох гэсэн бодлого тууштай баримталж байв.³ Нөгөө талаас ХБНГУ нь шинэхэн ардчилсан Монгол Улсыг хоёр их гүрний дунд орших өвөрмөц геополитикийн байрлалтайн зэрэгцээ эрчим хүчний арвин их түүхий эдийн нөөц бүхий Төв Азийн бүс нутагт эерэг нөлөө үзүүлж чадахуйц улс хэмээн харах болсон.

Ийнхүү хоёр талын эдгээр ашиг сонирхол харилцан нийцсэний үр дүнд 1992 оноос хойш Монгол-Германы харилцаа улам гүнзгийрч, шинэ шинэ салбараар хүрээгээ тэлэн, харилцан ашигтай хамтран ажиллах, “иж бүрэн түншлэл”-д хүрэх зорилтын дор хөгжих болсон билээ.

2.1. ХБНГУ-ын зүгээс Монгол Улсын талаар баримталсан бодлого, үйл ажиллагаа 1992-2005

1991 онд ЗХУ задран унах үед улс төр, эдийн засгийн хувьд бүрэн төлөвшөөгүй, хямралтай, дотооддоо болон хоорондоо янз бүрийн зөрчил мөргөлдөөний их, бага голомт бүхий шинэ тогтворгүй улсууд бий болсон. Гэвч Төв Ази, Кавказын бүс нутаг зүг ХБНГУ-ын анхаарал хандаж эхэлсэн. Учир нь Төв Ази, Кавказын бүс нутаг нь

Хэдийгээр Европын Холбоотой хиллээгүй боловч миграц мансууруулах бодисын наймааны урсгал тус бүсээр дамжин Европ руу чиглэх болсон нь Европын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байв. Мөн тэдний дотоодын дайн самуунд ОХУ болон бусад гуравдагч

² Мөн тэнд, 26 дугаар тал.

³ Ц.Лхам, Үндэсний ашиг сонирхол ба Монгол-Германы 1990 оноос хойшх үеийн харилцаа (Монголын талаас авч үзэхэд), Герман: Судалгаа, мэдээлэл, 2007. №1 (7), 102-106 дугаар тал.

ОЛОН УЛС СУДЛАЛ

орнууд хөндлөнгөөс оролцсон тохиолдолд Европын аюулгүй байдал хөндөгдөнө гэсэн болгоомжлол оршиж байсан нь хожим 1995 оны Европын Комиссын мэдэгдэлд тусгалаа олсон байна.⁴

Эрчим хүчний түүхий эдийн арвин баялаг нөөцөөрөө ХБНГУ Европын Холбоо (ЕХ) төдийгүй дэлхийн томоохон гүрнүүдийн анхаарлыг татаж байв.⁵ Тухайлбал, 1990 онд ЕХ нь Каспий орчмын нутгийг “Бүх Европын сонирхол”-ын бүс хэмээн зарласныг⁶ 1990 оны Европын Хамтын Нийгэмлэгийн Парисын хартаас үзэж болно. Мөн ХБНГУ 1992 онд гаргасан батлан хамгаалах бодлогын чиг баримтлалд “Германы бодлого нь дэлхийн эдийн засгийн шударга журмын үндсэн дээр дэлхий нийтийн худалдааг хамгаалах, түүхий эд болон дэлхийн зах зээлд саадгүй хүрэх язгуур ашиг сонирхлоо хэрэгжүүлэхийг удирдлага болгоно”⁷ хэмээн заасан байдаг.

Үүнээс үзэхэд, ХБНГУ нь Төв Азийн эрчим хүчний нөөцөд нэвтрэх, чингэхийн тулд эхлээд тэнд тогтвортой байдал бий болоход дэмжлэг үзүүлэх чиглэл баримталж байв.

Гэвч тухайн үед Төв Азид байдал тун ээдрээтэй, Тажикстанд 1992 онд иргэний дайн эхэлсэн, бүгдэд нь Ерөнхийлөгчийн дарангуйллын дэглэм төлөвшин тогтож буй тийм бүс нутагтай шууд үр дүнтэй хамтран ажиллах боломж бага байх тэр үед Монгол Улс нь Төв Ази төдийгүй Зүүн Азийн бүс нутгийн бүх улстай найрсаг харилцаатай, ямар нэгэн газар нутгийн маргаан, томоохон зөрчилгүй цорын ганц улс байсны дээр ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих давхар шилжилтийг тууштай хийж буй харьцангуй тогтвортой улс болон төлөвшиж байв.

⁴Mitteilung der Kommission, Die Beziehungen der Europäischen Union zu den neuen unabhängigen Staaten in Zentralasien, Kommission der Europäischen Gemeinschaften, Brüssel, den 10.10.1995. KOM (95) 206. (Комиссын мэдэгдэл, Европын Холбооны зүгээс Төв Азийн шинээр тусгаар тогтносон улсуудтай харилцах харилцаа, Европын Хамтын Нийгэмлэгийн комисс, Брюссель, 10.10.1995, KOM (95) 206.)

⁵Мөн тэнд.

⁶Alexander Rahr, Ukraine, Kaukasus und Zentralasien: Wie die Europäer das verschlafen. In: *KAS Auslandsinformationen*, 8/05, Politik, Juli 2003, 4 дүгээр тал. (Александр Раар, Украин, Кавказ ба Төв Ази: Европчууд “Great Game”-ээс хэрхэн хоцорч байна вэ? In: *KAS Auslandsinformationen* 8/05, Politik, Juli 2003, 4 дүгээр тал)

⁷Verteidigungspolitische Richtlinien für den Geschäftsbereich des Bundesministers der Verteidigung vom 26. November 1992 (Wortlaut), In: *Blätter für deutsche und internationale Politik*, №9'93, 1139 дүгээр тал. (1992.11.26-ны өдрийн Холбооны БХЯ-ны үйл ажиллагаанд баримтлах батлан хамгаалах бодлогын журам, In: *Blätter für deutsche und internationale Politik*, №9'93, 1139 дүгээр тал.)

Ийнхүү Монгол Улс нь Төв Азийн тогтвортой байдлын нэгэн бүрэлдэхүүн хэсэг болж буй байдал нь ХБНГУ-ын Төв Ази дахь сонирхолд нийцэж, цаашдаа ч Монгол Улс энэ бүс нутагт илүү их үүрэг рольтой байхыг Германы тал хүсэн хүлээсэн байх талтай юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улс цаашдаа энэ хувь нэмрээ хадгалан бататгах, өсгөн нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх явдал бол эцсийн дүндээ Төв Азийн бүс нутгийн тогтвортой байдлыг хангахад эерэг нөлөөтэй хэмээн Германы тал үзэж, Монгол Улс дахь ардчилал, шинэчлэлийн үйл явцад хүчтэй дэмжлэг үзүүлэх бодлогыг 1992 оноос хойш баримталж буй болов уу.⁸ ХБНГУ-ын эл бодлого хоёр талын харилцааны практикт хэрхэн хэрэгжсэнийг одоо авч үзье.

Улс төр, парламентын харилцаа: Холбооны Ерөнхийлөгч Роман Херцог 1998 онд, Холбооны Гадаад хэргийн сайд Клаус Кинкель 1996 онд, Бундестагийн Ерөнхийлөгч Н.Ламмерт 2006 онд, Бундестагийн Дэд Ерөнхийлөгч Д. Ю. Кроненберг 1991 онд, Бурхардт Хирш 1999 онд, Антьеэ Фольмер 1999, 2003 онд Монгол Улсад тус тус айлчилсан. Холбооны Ерөнхийлөгч Р. Херцог айлчлах үедээ “Монгол Улс нь умард, өмнөд их хөршүүд болон Төв Азийн шинэ орнуудтай яриа хэлцээний идэвхтэй бодлого явуулах замаар түншийн тогтвортой харилцаа тогтоож, урьдын хурцадмал байдлыг шинэ итгэлцлэлээр солихыг эрмэлзэж буйг бид сэтгэл нэн ханамжтай ажиглан харж байдаг” гэж хэлсэн нь Германы бодлогыг бас тодорхой хэмжээгээр харуулж байна.

Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа: Бээжинд суугаа Германы Элчин Сайдын Яамны цэргийн атташе, Бундесверийн Ерөнхий штабын хурандаа Шрөтер 1992 онд Монгол Улсад айлчилснаар хоёр тал анх холбоо тогтоож эхэлсэн. Улмаар 1993 онд Монгол Улс, ХБНГУ-тай цэргийн дипломат харилцаа тогтоож, 1994 оноос ХБНГУ-аас Монгол Улсад (хавсран) суух цэргийн атташе албан ёсоор ажилдаа орсон байна. 1995 онд “Бундесверийн Цэргийн сургуульд Монголын цэргийн боловсон хүчнийг сургаж, цэргийн боловсролын салбарт тусламж үзүүлэх тухай Монгол Улсын Батлан Хамгаалах Яам (БХЯ), ХБНГУ-ын БХЯ хоорондын гэрээ”, “Монгол

⁸ “Монголын ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үйл явцад оруулж буй Германы хувь нэмрийг бид зөвхөн Монголын хөгжилд төдийгүй, бүс нутгийнх нь хөгжилд оруулж буй бидний хувь нэмэр гэж ойлгодог” (Холбооны Батлан хамгаалахын сайд Р.Шарпинг, 2002 он)

⁹ “Холбооны Ерөнхийлөгчийн хэлсэн үг”, Ардын эрх, Улаанбаатар, 1995.09.20.

ОЛОН УЛС СУДЛАЛ

Улс, ХБНГУ-ын БХЯ-дын хамтын ажиллагааны тухай хамтарсан мэдэгдэл"-ийг тус тус байгуулсан.¹⁰ Энэ үед ХБНГУ Монголын зэвсэгт хүчин ардчилсан нийгэмд байр сууриа олоход нь дэмжлэг үзүүлэх, ялангуяа боловсон хүчний сургалт, семинар, мэргэжил дээшлүүлэх асуудалд гол анхаарлаа хандуулж байв.

Эдийн засгийн хамтын ажиллагаа: Монгол Улс, ХБНГУ-ын хоорондын хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхүүлэн дэмжих тухай гэрээнд хоёр тал 1991 онд, Орлогын болон хөрөнгийн татварыг давхардуулан ногдуулахгүй байх тухай хэлэлцээрт 1994 онд тус тус гарын үсэг зурсан.

ХБНГУ-ын зүгээс 1990-2006 онд 12 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн нь Монгол Улсад орж ирсэн нийт хөрөнгө оруулалтын 0,6 хувийг эзэлж, 17 дугаар байранд орж байв.¹¹ Монгол-Германы худалдааны эргэлт 2006 онд 57,9 сая евро болж байсан нь Монголын нийт худалдааны эргэлтийн 1,9 хувийг эзэлж байв.¹² Хоёр талын худалдаанд Германы тал ихэвчлэн ихээхэн ашигтай байдаг байна.

Энэ үе шатанд эдийн засгийн харилцааны үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд Монгол, Германы тал эдийн засгийн өдөрлөг, эдийн засгийн уулзалт, форум, соёлын өдөрлөг, үзэсгэлэн зэрэг 20 гаруй арга хэмжээг хамтран зохион байгуулсан байна.

Хөгжлийн хамтын ажиллагаа: ХБНГУ 1992-2006 онд 210.5 сая еврогийн хөгжлийн албан ёсны тусламж Монгол Улсад үзүүлсэн. Мөн үүний зэрэгцээ Конрад Аденауэрын Сан, Ханнс Зайделийн Сан, Фридрих Эбертийн Сан, Интеграцчилагдсан мэргэжилтнүүд (СІМ), Германы Хөгжлийн Алба (DED), Германы аж үйлдвэрийн ахмад мэргэжилтнүүдийн үйлчилгээ (SES), Карл Дуисбергийн Нийгэмлэг, Олон улсын хөгжлийн Германы сан (DSE) зэрэг байгууллагууд хөгжлийн албан ёсны бус тусламжийг Монголд үзүүлсээр байна.

Соёлын хамтын ажиллагаа: Хоёр тал 1991 оны Соёлын протоколыг 1995 онд дахин шинэчилж, 1997 онд Соёлын шинэ хэлэлцээр байгуулж,

¹⁰ "Ш. Содномжамц, Монголын офицеруудыг Германд сургагч". Ардын эрх. Улаанбаатар. 1995.10.05 №196(1155), 2 дугаар тал.

¹¹ ГХОГХА. 2006 оны мэдээ

¹² Aussenhandel nach Laendern und Warengruppen 2006. Statistisches Bundesamt, Dezember 2006 www.destatis.de

Соёлын протоколыг 2002 онд байгуулсан. Уг бичиг баримтуудыг хэрэгжүүлэх үйл явц соёлын хөтөлбөрт ажлууд, Германы Эрдмийн Солилцооны Алба(ГЭСА) болон бусад судалгааны сангуудын үйл ажиллагаа, хотуудын түншлэл, залуучууд, хэвлэл мэдээллийн болон спортын хамтын ажиллагаа гэсэн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдтэй явагдаж байна.

3. 2006 оноос хойшх үеийн Монгол-Германы харилцаа

2000-аад оны дунд үеэс дэлхийд эрчим хүчний болон бусад түүхий эдийн эрэлт нэмэгдэж, үнэ өсөх болсонтой холбогдуулан ХБНГУ-ын эрчим хүчний болон бусад түүхий эдийн гадаад бодлого эрчимжиж, улмаар энэ нь Монгол-Германы харилцаанд бодит тусгалаа үзүүлэх болсон тул энэ үеийг тусад нь авч үзэх болно.

Энэ үед Монгол-Германы харилцаанд Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого болон Германы Төв ба Зүүн Азийн бодлого урьдын адил эерэг нөлөө үзүүлж байснаас гадна Монголын ашигт малтмалын түүхий эдийг хоёр тал хамтран ашиглах гэсэн бодлого шинэ томоохон түлхэц өгөх болжээ.

3.1. 2006 оноос хойш ХБНГУ-аас Монгол Улсын талаар явуулж буй бодлого, үйл ажиллагаа

Дэлхийн нийтийн эдийн засгийн өсөлт, ялангуяа АНУ, Хятадын эдийн засгийн өсөлт, хоёрдугаарт, Хятад, Энэтхэг тэргүүлэн эрчимтэй хөгжиж буй Азийн орнуудын эрчим хүчний хэрэглээний эрс өсөлт, гуравдугаарт, эрчим хүчний түүхий эд нийлүүлэгч орнуудын улс төрийн тогтворгүй байдалтай холбоотойгоор дэлхийн зах зээл дээр нефть болон эрчим хүчний бусад түүхийн эдийн үнэ 2004, 2005 онд огцом нэмэгдсэн байна. 2004 онд нефть, нүүрсний үнэ 2002 оны үетэй харьцуулахад бараг 50%-иар нэмэгдсэн бол ураны үнэ бараг 150%-иар нэмэгдсэн байна.¹³ Гэтэл 1997-2007 оны хооронд ЕХ-ны эрчим хүчний түүхий эдийн импорт ОХУ, Норвеги, Ливи, Алжир зэрэг цөөн хэдхэн орноос хамааралтай байсан төдийгүй импортын хэмжээ 17%-иас

¹³ Kurzstudie, Reserven, Ressourcen und Verfügbarkeit von Energierohstoffen 2004, Stand 31.12.2004. Hrsg. Bundesanstalt für Geowissenschaften und Rohstoffe, 4 дүгээр тал. (Товч судалгаа, Нөөц баялаг ба эрчим хүчний түүхий эдийг эзэмших боломж 2004, 2004.12.31-ний байдлаар, Холбооны Геошинжлэх ухаан, түүхий эдийн газар, 4 дүгээр тал)

53,1% хүрч өсчээ.¹⁴

Үүнээс гадна энэ үед дэлхийн эдийн засгийн өсөлтийн улмаас зэс, алт, мөнгө зэрэг үнэт металлын үнэ ихээр нэмэгдэх болсон байна. Ялангуяа газрын ховор элементийн зах зээл дэх монопольт байдлаа ашиглан Хятад улс 2007 оноос эхлэн удаа дараа газрын ховор элементийн үнийг хөөрөгдөж байгаа нь¹⁵ Европын импортлогчдын бухимдлыг багагүй хүргэсээр байна.¹⁶ Гэвч Европын томоохон аж үйлдвэрүүдийн чухал түүхий эд болсон газрын ховор элементийн импортын 90% нь Хятадаас хамааралтай хэвээр байна.¹⁷

Эдгээр шалтгааны улмаас ХБНГУ болон ЕХ-ны хувьд эрчим хүчний, металлын, эрдсийн гаралтай түүхий эдийг харьцангуй тогтвортой үнээр найдвартай хангагдах, тэдгээр түүхий эдэд хүрэх шинэ гарцыг нээх, түүхий эдийг нийлүүлэгч улсын тоог нэмэгдүүлэх, олон талтай болгох явдал гадаад, дотоод бодлогын чухал зорилт болон тавигдах болов.

Эл зорилтыг хэрэгжүүлэхийн тулд ХБНГУ болон ЕХ-ны зүгээс олон янзын бодлого, хөтөлбөр, стратеги, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Тухайлбал, 2006 онд Европын Холбооны Комиссоос Ногоон ном буюу байнгын, өрсөлдөх чадвартай, найдвартай эрчим хүчний стратегийн баримт бичиг,¹⁸ 2007 онд Европын Комиссоос “Европын Холбоо ба Төв Ази: Шинэ түншлэлийн төлөө хөтөлбөр”, 2010 онд ХБНГУ-ын Холбооны Гадаад яамнаас “Герман ба Төв Ази-

¹⁴ Stellungnahme des Europäischen Wirtschafts- und Sozialausschusses zum Thema „Energieversorgung: Wie muss eine Nachbarschaftspolitik aussehen, die die Versorgungssicherheit der EU gewährleistet“, Brüssel, den 15. März 2011. 5 дугаар тал. (“Эрчим хүчний хангамж: ЕХ-ны хангамжийн аюулгүй байдлыг бататгаж буй Хөршийн бодлого ямар байх ёстой вэ?” сэдвээр Европын Эдийн засаг, нийгмийн хорооны баримтлах байр суурь, Брюссель, 2011.03.15, 5 дугаар тал)

¹⁵ Maren Liedtke, Harald Elsner, Seltene Erden, *In: Commodity top news* Nr.31, Fakten, Analysen, Wirtschaftliche Hintergrundinformationen. Hannover 2009, 3 дугаар тал. (Марен Лийдтке, Харальд Элзнер, Газрын ховор элемент, *In: Commodity top news* Nr.31, Баримт, Анализ, Эдийн засгийн уг суурь мэдээлэл, Ханновер 2009, 3 дугаар тал)

¹⁶ Felix Lee, Abhängig von China, 11.02.2011, <http://www.zeit.de/wirtschaft/2011-02/china-seltene-erden> (Феликс Лээ, Хятадаас хамааралтай байх нь, <http://www.zeit.de/wirtschaft/2011-02/china-seltene-erden>)

¹⁷ Grundstoffmärkte und Rohstoffe: Herausforderungen und Lösungsansätze. Mitteilung der Kommission an das Europäische Parlament, den Rat, den europäischen Wirtschafts- und Sozialausschuss und den Ausschuss der Regionen. Brüssel, den 2.2.2011, KOM(2011) 25 endgültig, 25-26 дугаар тал. (Communication from the Commission to the European Parliament, the Council, the European economic and social committee and committee of the Regions, Tackling the challenges in commodity markets and raw materials. Brussels, 2.2.2011, COM(2011) 25 final, p.25-26.)

¹⁸ Green Paper, A European Strategy for sustainable, competitive and secure Energy. Brussels, 8.3 2006, COM(2006) 105 final.

ирээдүйн түншлэл” стратегийн баримт бичиг.¹⁹ 2010 онд ХБНГУ-ын Холбооны Засгийн газраас “Холбооны Засгийн газрын түүхий эдийн стратеги”,²⁰ 2011 онд Европын Комиссоос “Үндсэн түүхий эдийн зах зээл ба түүхий эд: Тулгамдсан асуудлууд болон шийдвэрлэх арга зам” мэдэгдлийг²¹ тус тус гаргасан байна.

2007 оны “Европын Холбоо ба Төв Ази: Шинэ түншлэлийн төлөө хөтөлбөр” стратегийн баримт бичигт, “... ЕХ эрчим хүчний гадаад эх үүсвэрээс хараат байдал болон эрчим хүчний аюулгүй байдлаа илүүтэй хангах зорилгоор эрчим хүчний хангамжийг олон талтай болгох хэрэгцээ шаардлагатай байгаа зэрэг нь ЕХ болон Төв Азийн хоорондын хамтын ажиллагааны цаашдын төлвийг нээн өгч байна. ...ЕХ нь энх тайванч, ардчилсан, эдийн засгийн хувьд цэцэглэн хөгжиж буй Төв Азийг маш их сонирхдог. ...Төв Азийн орнууд олон улсын эрх зүй, эрх зүйт төр, хүний эрх, ардчиллын үнэт зүйлс болон зах зээлийн эдийн засгийг баримтлах амлалтаа бататгах нь Төв Ази дахь аюулгүй байдал, тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх бөгөөд ингэснээр тус бүс нутгийн улсуудыг ЕХ-той хуваалцаж болох нэгдмэл ашиг сонирхол, зорилго бүхий найдвартай түншүүд болгох болно.” гэжээ.²² Уг баримт бичгийн хэрэгжилтийн байдалд онцгой анхаарал тавьж, 2008, 2010, 2012 онд Европын Комиссын зүгээс хэрэгжилтийн явцыг нэгтгэн дүгнэсэн мэдэгдэл гаргасан байдаг.²³

ХБНГУ болон ЕХ-ны эл нөхцөл байдал, бодлого чиглэл нь 2006 оноос хойш Монгол-Германы харилцаанд доорх байдлаар тусгалаа тусгалаа олж байна. Нэгдүгээрт, Монголын ашигт малтмалын арвин их

¹⁹ Zentralasienstrategie: Deutschland und Zentralasien – eine Partnerschaft für die Zukunft. Auswärtiges Amt, 2010. (Төв Азийн стратеги: Герман ба Төв Ази- ирээдүйн төлөөх түншлэл, Гадаад хэргийн яам, 2010)

²⁰ Rohstoffstrategie der Bundesregierung, Sicherung einer nachhaltigen Rohstoffversorgung Deutschlands mit nicht-energetischen mineralischen Rohstoffen, Bundesministerium für Wirtschaft und Technologie, Oktober 2010. (The German Government's raw materials strategy. Safeguarding a sustainable supply of non-energy mineral resources for Germany, Federal Ministry for Economics and Technology, 2010)

²¹ Communication from the Commission to the European Parliament, the Council, the European economic and social committee and committee of the Regions, Tackling the challenges in commodity markets and raw materials, Brussels, 2.2.2011, COM(2011) 25 final.

²² The EU and Central Asia: Strategy for a new partnership, Council of the European Union, General Secretariat, Brussels 2007, 6,8-9 дүгээр тал.

²³ Progress Report by the Council and the European Commission to the European Council on the implementation of the EU Strategy for Central Asia, Brussels, 24. June 2008; Joint Progress Report by the Council and the European Commission to the European Council on the implementation of the EU Strategy for Central Asia. 11402/10, Council of the European Union, Brussels, 28. June 2010; Progress Report on the implementation of the EU Strategy for Central Asia, 11455/12, Brussels 2012,

ОЛОН УЛС СУДЛАЛ

нөөц, үүнд ялангуяа, коксжих нүүрс, газрын ховор элементын ордыг хамтран ашиглах, хоёрдугаарт, Монгол Улс нь Төв Азийн орнуудад ардчиллын үлгэр жишээ үзүүлэх, туршлагаасаа хуваалцах, бүс нутгийн орнуудын харилцан итгэлцэл, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд идэвх санаачлагатай оролцох зэрэг Монгол Улсын оруулах хувь нэмрийг хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд дэмжих зэрэг болно.

Үүний зэрэгцээ Азийн орнуудын эдийн засгийн хурдацтай өсөлт, хүчийг өөрсдийн эдийн засгаа хөгжүүлэхэд ашиглах бодлого нь ХБНГУ болон ЕХ-ны түүний стратегийн сонирхлын төвд оршсоор байна. Гэвч энэ сонирхлоо хэрэгжүүлэхэд Ази тивд энх тайван, аюулгүй байдлыг хадгалан хамгаалах явдал чухлаас чухалд тавигдаж байна.²⁴ Иймд Хойд Солонгосын цөмийн зэвсгийн хөтөлбөр, Хятад-Япон, Хойд Солонгос-Японы маргаантай асуудлууд гэх зэрэг олон зөрчлийг эв эээр зохицуулах, харилцан ойлголцолд хүргэх, Зүүн Азийн бүс нутагт итгэлцлийг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг өрнүүлэхэд ардчилсан, энх тайванч, бүс нутгийн улсуудтай бүгдтэй нь сайн харилцаатай Монгол Улс дорвитой үүрэг гүйцэтгэх боломжтой ажээ.²⁵ Энэ бодлого нь хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд 2006 оноос хойш хэрхэн хэрэгжсэнийг дор цухас дурдая.

Улс төрийн харилцаа: 2011 онд Холбооны Канцлер Ангела Меркель, 2008 онд Холбооны Ерөнхийлөгч Хорст Кёэлэр, 2007 онд Холбооны эдийн засаг, технологийн сайд М.Глос, 2010 онд Холбооны эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн сайд Д.Нийбель, Холбооны зам тээвэр, хот байгуулалтын сайд П.Рамзауэр, 2014 онд Холбооны Гадаад хэргийн сайд Ф.Штайнмайер тус тус Монгол Улсад айлчилсан. Энэ үед Холбооны Канцлер анх удаа Монголд айлчилснаас гадна Холбооны сайд нар ойр ойрхон ирсэн нь тэмдэглүүштэй үйл явдал байв. Ерөнхийлөгч Х.Кёэлэрийн айлчлалын үеэр **“Монгол Улс, ХБНГУ-ын хоорондын иж бүрэн түншлэлийн тухай Хамтарсан**

²⁴ Энэ тухай ХБНГУ-ын 1993 оны Азийн үзэл баримтлал, 1994 онд Европын Комиссоос гаргасан “Шинэ Азийн түншлэлийн төлөв” мэдэгдэл, 2001 онд Европын Комиссоос гаргасан “Европ ба Ази. Оргон түншлэлд хүрэх стратегийн үндэс суурь” мэдэгдэл, ХБНГУ-ын 2002 оны Азийн үзэл баримтлал, Зүүн Ази, Зүүн өмнөд Ази, Өмнөд Азийн бүс нутгийн үзэл баримтлал, 2007 онд ЕХ-ны Зөвлөлөөс гаргасан Зүүн Ази дахь ЕХ-ны гадаад болон аюулгүй байдлын бодлогын тухай үндсэн баримт бичиг, үүнийг 2012 онд шинэчлэн гаргасан хувилбараас дэлгэрэнгүй үзэж танилцаж болно.

²⁵ Ральф Тийле, Монгол Улсын “Гурав дахь хорш”-ийн бодлого, түүний бүс нутаг хийгээд дэлхий нийтийн аюулгүй байдал, цэрэг улс төрийн хэтийн төлөв, Монгол, Германы харилцаа өнөөгийн байдал ба хэтийн төлөв, Улаанбаатар 2013, 39 дүгээр тал.

тунхаглал”-д гарын үсэг зурсан нь өнөөг хүртэл хоёр талын хамтын ажиллагааны нэгэн чухал баримт бичиг болж байна.

Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа: 2010 онд Батлан хамгаалахын сайд Цү Гүттенберг Монгол Улсад айлчилсан бөгөөд хоёр тал 2008 онд Батлан хамаалах салбарын хамтын ажиллагааны тухай БХЯ-д хоорондын тохиролцоо, 2009 онд БХЯ-дын хоорондын Цэргийн нууц хадгалах тохиролцоо, 2009 онд Афганистан улсад аюулгүй байдлыг сахиулах олон улсын цэргийн хүчний ажиллагаанд хамтран ажиллах, дэмжлэх үзүүлэх тухай хоёр талын БХЯ-д хоорондын тохиролцоог тус тус байгуулсан. 2009 оны 12 дугаар сараас хойш Афганистан улсад аюулгүй байдлыг сахиулах олон улсын цэргийн хүчний ажиллагаанд Монгол Улс ХБНГУ-ын багийн командлал дор хамтран оролцож буйтай холбогдуулан Монголын цэргийн багийн ажиллагааны өмнөх сургалтыг ХБНГУ-ын Зэвсэгт хүчний сургагч багш нар удирдан явуулж байна.

Эдийн засгийн болон эрдэс баялгийн хамтын ажиллагаа: 2010 оны түүхий эдийн стратегийн хүрээнд ХБНГУ нь анх удаа “Түүхий эдийн түншлэл”-ийг Монгол Улстай байгуулахаар шийдвэрлэж, улмаар 2011 онд Канцлер Меркелийн айлчлалын үеэр “Ашигт малтмал, аж үйлдвэр болон технологийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т гарын үсэг зурсан. Түүнчлэн Сийменс, Тюссен Крупп, ББМ Оперта, Дойче Баан, Дойче Банк зэрэг Германы томоохон аж ахуйн нэгж, санхүүгийн байгууллагууд Монголд цахилгаан станцын тоног төхөөрөмж нийлүүлэх, нүүрс шингэрүүлэн түлш үйлдвэрлэх, коксжих нүүрсний ордод гэрээт олборлогчоор ажиллах, төмөр зам барих, олон улсын хөрөнгийн биржид уул уурхайн томоохон компанийн хувьцааг арилжаалахад хамтран ажиллах тухай яриа хэлэлцээг хийгээд байна.

Мөн эдийн засгийн бусад салбаруудад ч хамтын ажиллагаа өрнөж байна. Тухайлбал, 2007 онд хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах тухай протокол, 2009 онд Монгол Улсын эдийн засгийн удирдах менежерүүдийг давтан сургахад хамтран ажиллах тухай санамж бичиг, 2009 онд Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын салбарын хамтын ажиллагааны тухай протоколыг хоёр орны Засгийн газрын түвшинд

ОЛОН УЛС СУДЛАЛ

тус тус байгуулан идэвхтэй хамтран ажиллаж байна.²⁶

1990-2013 онд Монгол Улсад оруулсан ХБНГУ-ын нийт хөрөнгө оруулалт 61 сая ам.долларт хүрсэн нь Монголын нийт хөрөнгө оруулалтын 0,44 хувийг эзэлж, 18 дугаар байранд орж байв.²⁷

Монгол-Германы худалдааны эргэлт 2013 онд 183,7 сая еврод хүрснээс Монголын талын импорт нь 172,3 сая евро, Монголын эскпорт нь 11,4 сая евро болсон байна.²⁸

Хөгжлийн хамтын ажиллагаа: ХБНГУ 1992-2013 онд нийт 300 сая гаруй еврогийн хөгжлийн албан ёсны тусламж үзүүлээд²⁹ байгаа бөгөөд 2011 оноос хойш хөгжлийн хамтын ажиллагааг эрчим хүчний үр ашиг, ашигт малтмалын тогтвортой менежментийг хөхиүлэн дэмжих, биологийн төрөл зүйл гэсэн гурван тэргүүлэх чиглэлд төвлөрүүлэн хэрэгжүүлэхээр хоёр тал харилцан тохироод байна.³⁰

Соёл, боловсрол, шинжлэх ухаан, бусад хамтын ажиллагаа: Хоёр орны соёлын хэлэлцээр, протоколын хүрээнд Боннын их сургуулийн монголч эрдэмтэд Монголын соёлын үнэт өв болох үйсэн дээрх бичгийг сэргээх төслийг хэрэгжүүлж, хоёр орны эрдэмтэд Монголын эртний нийслэл Хархорин хот, Монгол Алтай, Орхоны Хар балгаст археологийн хамтарсан малтлага хийх төслийг амжилттай үргэлжлүүлсээр байна. 2007 онд Улаанбаатар хотноо Германы археологийн хүрээлэнгийн салбар, 2009 онд Гёте Институтын төлөөлөгчийн газар Улаанбаатар хотод албан ёсоор нээгдсэн.

Хоёр орны хамтран байгуулж буй Монгол-Германы технологийн дээд сургууль 2013 оны намар нээлтээ хийж, инженер бэлтгэлийн хөтөлбөрийн үйл ажиллагаа эхэлсэн. Харин бакалаврын зэрэг олгох анхны сургалт 2014 оны намар эхлэх ажээ.³¹ Мөн Монгол Улсын уул

²⁶ Монгол Улс, ХБНГУ-ын харилцааны лавлах, МУ-ын Гадаад Харилцааны Яамны төв архив, СХ №70, Д №1, ХН №188, Монгол-Германы харилцаа 2010 он.

²⁷ Гадаад Хөрөнгө Оруулалтын Газрын мэдээ, 2013 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар

²⁸ Wirtschaftsdaten kompakt: Mongolei, Germany Trade and Invest, Stand: Mai 2014. 3 дугаар тал

²⁹ Б.Мандахбилэг, Монгол-Германы харилцаа, хамтын ажиллагааны талаар тавих илтгэл, Монгол, Германы харилцаа өнөөгийн байдал ба хэтийн төлөв, Улаанбаатар 2013, 14 дүгээр тал.

³⁰ Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хөгжлийн хамтын ажиллагааны хэлэлцээний протокол, Бонн хот, 2012 оны 3 дугаар сарын 26-27-ны өдөр, 1 дүгээр тал.

³¹ Монгол-Германы Технологийн Дээд Сургууль: Дэлхийн түвшний инженерийг Монголд бэлтгэнэ. <http://www.gmit.edu.mn/article/196/>

уурхайн салбарт ажиллах өндөр боловсролтой мэргэжилтэн бэлтгэх зорилгоор 2010 онд ГЭСА-тай хамтран эхлүүлсэн “Хамтарсан тэтгэлгийн хөтөлбөр”-ийн хүрээнд 2010-2012 онд 40 гаруй монгол оюутан ХБНГУ-д суралцсан бөгөөд уг хөтөлбөрийг 2013-2015 сунган хэрэгжүүлэхээр болсон.³²

Иж бүрэн түншлэлийг хөгжүүлэх зорилтын дагуу Монгол-Германы хамтын ажиллагаа улам бүр тэлэн гүнзгийрч, шинэ шинэ салбар, байгууллагуудыг хамрах болжээ. Жишээлбэл, хөдөлмөр ниймийн хамгаалал, эрүүл мэндийн байгууллагууд, цагдаа, архив, статистик, муж улс, хот дүүргийн түншлэл гэх мэт.

ХБНГУ болон ЕХ-ны Төв болон Зүүн Ази дах ашиг сонирхлоо хангахын тулд тухайн бүс нутгийн хүчин зүйлсийг Монгол Улстай харилцах харилцаатай нягт уялдуулан ухаалгаар ашиглаж буй хэдий ч үүнд өөр олон хүчин зүйлс хүчтэй шууд нөлөө үзүүлж буйг дурдахгүй өнгөрч болохгүй юм. Энэ бүх хүчин зүйлсийн нөлөөгөөр хүрсэн үр дүнг буюу ХБНГУ-ын Төв ба Зүүн Ази дах ашиг сонирхол хэр зэрэг хангагдаж буйг тоймлон харж байх нь чухал билээ.

Каспийн тэнгисийн сав газрын байгалийн хийг Германы хажууханд буюу Австрид аваачих байсан Набуко (Nabucco) төсөл 2013 оны 6 дугаар сард бүтэлгүйтсэн боловч харин оронд нь Өмнөдийн Зурвас (Southern Gas Corridor)-ын нэгэн хувилбар болох ТАП (ТАР буюу Trans-Adriatic Pipeline) төсөл дэмжигдсэн билээ. Ингэснээр Азербайжаны магадгүй цаашлаад Төв Азийн байгалийн хийг Европын Итали хүртэл тээвэрлэх боломж бий болох бөгөөд энэ нь Европын эрчим хүчний түүхий эдийн хангамжийг олон талтай болгоход тодорхой хувь нэмэр болох биз ээ.

Дүгнэлт

1990 оноос хойш Монгол-Германы харилцаа эрс идэвхжиж, улмаар алхам алхмаар өргөжин гүнзгийрч байна. Ийнхүү хөгжихөд түлхэц үзүүлсэн гол хүчин зүйлсийг 1990-1992, 1992-2005, 2006 оноос

³² Ч.Шинэбаяр, Монгол-Германы хамтын ажиллагаа дээд боловсролын салбар, Монгол, Германы харилцаа өнөөгийн байдал ба хэтийн төлөв, Улаанбаатар 2013, 104 дүгээр тал.

ОЛОН УЛС СУДЛАЛ

хойш гэсэн үндсэн гурван үечлэл тус бүрд хамтын ажиллагааны бодит үйл ажиллагаа, хэлсэн үг, гаргасан баримт бичигт зэрэгт тулгуурлан шинжлэн судалж, олж тодруулахад доорх дүр зураг харагдаж байна.

Нэгдүгээрт, Монгол Улсын хувьд 1990-ээд оны эхэн үеэс хойш гадаад улс төр, геополитикийн цоо шинэ нөхцөл байдалд нийцэн зохицохын зэрэгцээ дотоод эдийн засгийн уналтын байдлаасаа гарахын тулд ХБНГУ-ын тус дэмжлэгийг бүхий л талаар авах бодлогыг түлхүү баримталж байсан бөгөөд төдөлгүй Монгол Улс нь ХБНГУ-ыг “гуравдагч хөрш”-өө болгох гэсэн бодлогоо тууштай баримтлах болжээ.

Хоёрдугаарт, ХБНГУ нь БНАГУ-ыг өвлөн авагч улс болохын хувьд БНАГУ-БНМАУ-ын хуучин хамтын ажиллагааны төвшинг аль болох бууруулахгүй байх бодлогыг эхэн үедээ баримталж байснаа 1992 оноос Германы бодлого, үйл ажиллагаа нь Монгол Улс Төв Азийн орнуудад ардчиллын үлгэр жишээ үзүүлэх, туршлагаасаа хуваалцах, бүс нутгийн орнуудын харилцан итгэлцэл, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд идэвх санаачлагатай оролцох зэрэг хувь нэмрийг нь хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд дэмжихэд чиглэх болжээ. Харин 2006 оноос хойш Монголын ашигт малтмалын арвин их нөөц, үүнд ялангуяа, коксжих нүүрс, газрын ховор элементын ордыг хамтран ашиглах хэрэгцээ шаардлага бий болж байна.

Эдгээр бодлого чиглэл, хүчин зүйлсээс Төв ба Зүүн Азийн хүчин зүйлийг онцлон үзэж, энэхүү өгүүллийн хүрээнд Монгол-Германы 1990 оноос хойшх харилцаанд хэрхэн нөлөөлж буй, чухам яагаад нөлөөлөх болсон зэргийг задлан судалж үзлээ. Чингэхэд, нэг талаас Төв ба Зүүн Азийн бүс нутагт тогтвортой байдал, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх гэсэн Монгол Улсын идэвхтэй байр суурь, бодит үйлдэл, цаана өөрт нь хадгалагдаж буй ихээхэн боломж, нөгөө талаас энэхүү боломжийг ашиглан Төв ба Зүүн Азид тогтвортой байдал, харилцан ойлголцлыг бэхжүүлэх гэсэн ХБНГУ-ын бодлого харилцан нийцсэн учраас энэ нь 1990-ээд оноос хойшхи Монгол-Германы харилцаанд эерэг нөлөө үзүүлж буй нэгэн хүчин зүйл болж чаджээ гэсэн дүгнэлтэнд хүрч байна.

Төв ба Зүүн Азийн бүс нутгийн тогтвортой байдлыг хангахад тухайн бүс нутагт оршдог Монгол Улсыг дэмжин ашиглах бодлогоо Герман, Европын тал хэрхэн хэрэгжүүлж буйг энэхүү өгүүллийн хүрээнд мөшгин судлах явцдаа аливаа асуудалд ул суурьтай, нухацтай, хийдэлгүй цогцоор нь ханддаг герман ухаан, герман сэтгэхүй, герман чанарыг эцэст нь олж харлаа. Энэ нь өөрийн сонирхлыг нөгөө талын ашиг сонирхолтой ухаалгаар уялдуулах замаар бодлогоо хэрэгжүүлдэг байсан Холбооны анхны Канцлер асан Конрад Аденауэрын гадаад бодлогын залгамж чанар Германы бодлогод эдүгээ ч хадгалагдаж буйг харуулж байна.

Ном зүй

1. Ц.Лхам, Монгол-Германы харилцааг үечлэх асуудалд (1990 оноос хойш), Герман: Судалгаа, мэдээлэл, 2007. Nr.2 (8).
2. Ц.Лхам, Үндэсний ашиг сонирхол ба Монгол-Германы 1990 оноос хойшх үеийн харилцаа (Монголын талаас авч үзэхэд). Герман: Судалгаа, мэдээлэл, 2007. Nr.1 (7).
3. Mitteilung der Kommission, Die Beziehungen der Europäischen Union zu den neuen unabhängigen Staaten in Zentralasien, Kommission der Europäischen Gemeinschaften, Brüssel, den 10.10.1995, KOM (95) 206.
(Комиссын мэдэгдэл, Европын Холбооны зүгээс Төв Азийн шинээр тусгаар тогтносон улсуудтай харилцах харилцаа. Европын Хамтын Нийгэмлэгийн комисс, Брюссель, 10.10.1995, КОМ (95) 206.)
4. Alexander Rahr, Ukraine, Kaukasus und Zentralasien: Wie die Europäer das verschlafen, In: *KAS/Auslandsinformationen*, 8/05, Politik, Juli 2003.
(Александр Раар, Украин, Кавказ ба Төв Ази: Европчууд “Great Game”-ээс хэрхэн хоцорч байна вэ? In: *KAS/Auslandsinformationen*, 8/05, Politik, Juli 2003)
5. Verteidigungspolitische Richtlinien für den Geschäftsbereich des Bundesministers der Verteidigung vom 26.November 1992 (Wortlaut), In: *Blätter für deutsche und internationale Politik*, №9’93, 1139 дүгээр тал.
(1992.11.26-ны өдрийн Холбооны БХЯ-ны үйл ажиллагаанд

- баримтлах батлан хамгаалах бодлогын журам, *In: Blätter für deutsche und internationale Politik*, №9'93)
6. “Холбооны Ерөнхийлөгчийн хэлсэн үг”, Ардын эрх, Улаанбаатар. 1995.09.20.
 7. “Ш. Содномжамц, Монголын офицеруудыг Германд сургана”. Ардын эрх, Улаанбаатар, 1995.10.05. №196(1155).
 8. Д.Галсандорж, “Монгол, Германы худалдаа, хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал”, Монгол-Германы харилцаа, Өнгөрсөн үе. эдүгээ, хэтийн төлөв, Улаанбаатар 2004.
 9. Kurzstudie, Reserven, Ressourcen und Verfügbbarkeit von Energierohstoffen 2004, Stand 31.12.2004, Hrsg. Bundesanstalt für Geowissenschaften und Rohstoffe.
(Товч судалгаа, Нөөц баялаг ба эрчим хүчний түүхий эдийг эзэмших боломж 2004, 2004.12.31-ний байдлаар. Холбооны Геошинжлэх ухаан, түүхий эдийн газар)
 10. Stellungnahme des Europäischen Wirtschafts- und Sozialausschusses zum Thema „Energieversorgung: Wie muss eine Nachbarschaftspolitik aussehen, die die Versorgungssicherheit der EU gewährleisten“. Brüssel, den 15. März 2011.
(“Эрчим хүчний хангамж: ЕХ-ны хангамжийн аюулгүй байдлыг бататгаж буй Хөршийн бодлого ямар байх ёстой вэ?” сэдвээр Европын Эдийн засаг, нийгмийн хорооны баримтлах байр суурь. Брюссель, 2011.03.15)
 11. Maren Liedtke, Harald Elsner, Seltene Erden, *In: Commodity top news* Nr.31, Fakten, Analysen, Wirtschaftliche Hintergrundinformationen. Hannover 2009.
(Марен Лийдтке, Харальд Элзнер, Газрын ховор элемент, *In: Commodity top news* Nr.31, Баримт, Анализ, Эдийн засгийн уг суурь мэдээлэл, Ханновер 2009)
 12. Felix Lee, Abhängig von China, 11.02.2011, <http://www.zeit.de/wirtschaft/2011-02/china-seltene-Erden>
(Феликс Лээ, Хятадаас хамааралтай байх нь, <http://www.zeit.de/wirtschaft/2011-02/china-seltene-Erden>)
 13. Grundstoffmärkte und Rohstoffe: Herausforderungen und Lösungsansätze, Mitteilung der Kommission an das Europäische Parlament, den Rat, den europäischen Wirtschafts- und Sozialausschuss und den Ausschuss der Regionen, Brüssel, den 2.2.2011, KOM (2011) 25 endgültig.

- (Communication from the Commission to the European Parliament, the Council, the European economic and social committee and committee of the Regions, Tackling the challenges in commodity markets and raw materials, Brussels, 2.2.2011, COM(2011) 25 final)
14. Green Paper, A European Strategy for sustainable, competitive and secure Energy, Brussels, 8.3.2006, COM (2006) 105 final.
 15. Zentralasienstrategie: Deutschland und Zentralasien – eine Partnerschaft für die Zukunft, Auswärtiges Amt, 2010.
(Төв Азийн стратеги: Герман ба Төв Ази- ирээдүйн төлөөх түншлэл, Гадаад хэргийн яам, 2010)
 16. Rohstoffstrategie der Bundesregierung, Sicherung einer nachhaltigen Rohstoffversorgung Deutschlands mit nicht-energetischen mineralischen Rohstoffen, Bundesministerium für Wirtschaft und Technologie, Oktober 2010.
(The German Government's raw materials strategy, Safeguarding a sustainable supply of non-energy mineral resources for Germany. Federal Ministry for Economics and Technology, 2010)
 17. The EU and Central Asia: Strategy for a new partnership, Council of the European Union, General Secretariat, Brussels 2007.
 18. Progress Report by the Council and the European Commission to the European Council on the implementation of the EU Strategy for Central Asia, Brussels, 24. June 2008; Joint Progress Report by the Council and the European Commission to the European Council on the implementation of the EU Strategy for Central Asia. 11402/10, Council of the European Union, Brussels, 28. June 2010; Progress Report on the implementation of the EU Strategy for Central Asia, 11455/12, Brussels 2012,
 19. Ральф Тийле, Монгол Улсын “Турав дахь хөрш”-ийн бодлого, түүний бүс нутаг хийгээд дэлхий нийтийн аюулгүй байдал, цэрэг улс төрийн хэтийн төлөв, Монгол, Германы харилцаа өнөөгийн байдал ба хэтийн төлөв, Улаанбаатар 2013, 39 дүгээр тал.
 20. Монгол Улс, ХБНГУ-ын харилцааны лавлах, МУ-ын Гадаад Харилцааны Яамны төв архив, СХ №70, Д №1, ХН №188, Монгол-Германы харилцаа 2010 он.
 21. Гадаад Хөрөнгө Оруулалтын Газрын мэдээ, 2013 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар
 22. Wirtschaftsdaten kompakt: Mongolei, Germany Trade and Invest,

ОЛОН УЛС СУДЛАЛ

Stand: Mai 2014.

23. Б.Мандахбилэг, Монгол-Германы харилцаа, хамтын ажиллагааны талаар тавих илтгэл, Монгол, Германы харилцаа өнөөгийн байдал ба хэтийн төлөв. Улаанбаатар 2013.
24. Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хөгжлийн хамтын ажиллагааны хэлэлцээний протокол, Бонн хот, 2012 оны 3 дугаар сарын 26-27-ны өдөр, 1 дүгээр тал.
25. Монгол-Германы Технологийн Дээд Сургууль: Дэлхийн түвшний инженерийг Монголд бэлтгэнэ, <http://www.gmit.edu.mn/article/196/>
26. Ч.Шинэбаяр, Монгол-Германы хамтын ажиллагаа дээд боловсролын салбар, Монгол, Германы харилцаа өнөөгийн байдал ба хэтийн төлөв, Улаанбаатар 2013, 104 дүгээр тал.
27. “Аюулгүй байдлын баталгаа-Клинтонд илгээлт явуулав”, Үнэн. Улаанбаатар, 1993.11.15, №98 (18265), 1-р тал.
28. Дэд сайд Д.Ганхуяг Зүүн хойд Азийн асуудлаарх “Улаанбаатарын яриа хэлэлцээ”-ний тухай танилцуулав, 2013.11.12, http://www.mfa.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=2861%3A2013-11-12-09-14-01&catid=43%3A2009-12-20-21-55-03&Itemid=62&lang=mn